

"ҮЦТХТ" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн
09 дүгээр тогтоолын хавсралт

МӨНГӨН ХӨРӨНГИЙН ГҮЙЛГЭЭНИЙ ЖУРАМ
/Шинэчилсэн найруулга/

*/“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025
оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

“ҮЦТХТ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн
09 дүгээр тогтоолын хавсралт



МӨНГӨН ХӨРӨНГИЙН ГҮЙЛГЭЭНИЙ ЖУРАМ
/Шинэчилсэн найруулга/

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журам нь биржийн болон биржийн бус арилжааны үнийн дүнд үүссэн төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж дахь мөнгөн хөрөнгийн гүйлгээг хийж гүйцэтгэх явцад үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2. Энэхүү харилцаанд Монгол улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны (цаашид “Хороо” гэх) Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам, Монголбанкны банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журам, Монголбанкны банк хоорондын бага дүнтэй төлбөр тооцооны журам, Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам, Кастодианы гишүүнчлэлийн журам, Автомат клиринг хаус систем /ACH/-ийн дүрэм, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /цаашид “Төвлөрсөн хадгаламжийн төв” гэх/-ийн холбогдох журмуудыг удирдлага болгоно.
- 1.3. Биржийн болон биржийн бус арилжаагаар хийгдсэн үнэт цаасны өмчлөх эрх шилжүүлэх /бэлэглэх, өв залгамжлах, зээлийн барьцаа, шүүх, цагдаагийн байгууллагын шийдвэрээр үнэт цаас болон мөнгөн хөрөнгө шилжүүлэх, дуудлага худалдаагаар төрийн мэдлийн хувьцаа шилжүүлэх түүний шимтгэл хураамж болон холбогдох бусад мөнгөн хөрөнгийн гүйлгээг Төвлөрсөн хадгаламжийн төвийн төлбөр хариуцсан алба хийж гүйцэтгэнэ.
- 1.4. Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж дахь мөнгөн хөрөнгийн гүйлгээг энэ журмын 1.2-т заасан зохицуулалтад нийцүүлэн оролцогч талуудтай байгуулсан гэрээний үндсэн дээр хэрэгжүүлнэ.
/ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор нэмсэн/

Хоёр. Нэр томъёоны тайлбар

- 2.1. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.
 - 2.1.1. “Үнэт цаас” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5.1-д зааснаар ойлгох;
 - 2.1.2. “Өрийн хэрэгсэл” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.9-д зааснаар ойлгох;
 - 2.1.3. “Мөнгөн хөрөнгийн баланс” гэж дансны үлдэгдэл сан дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь өмнөх өдрийн үлдэгдэл дээр тухайн

өдрийн орлогыг нэмж, зарлагыг хасаж гаргасан үлдэгдэлтэй тэнцэх тэнцвэрийг;

- 2.1.4. “Анхан шатны баримт” гэж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3, 13.3-т заасан баримт;
- 2.1.5. “Их дүнтэй гүйлгээ” гэж Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан хязгаартай тэнцүү буюу түүнээс дээш үнийн дүнтэй банк хоорондын гүйлгээг;
- 2.1.6. “Бага дүнтэй гүйлгээ” гэж Монгол банкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан хязгаартай тэнцүү буюу доош үнийн дүнтэй банк хоорондын гүйлгээг;
- 2.1.7. “Мэдээллийн сан” гэж Төвлөрсөн хадгаламжийн төвийн төвлөрсөн хадгаламж дахь харилцагчдын мэдээллийг хадгалж буй санг;
- 2.1.8. “Орлогын гүйлгээ” гэж арилжааны банкнаас төвлөрсөн хадгаламжийн төвийн данс руу шилжүүлсэн гүйлгээ;
- 2.1.9. “Зарлагын гүйлгээ” гэж Төвлөрсөн хадгаламжийн төвийн данснаас арилжааны банк руу шилжүүлсэн гүйлгээ;
- 2.1.10 “Төлбөрийн гишүүн” гэж Төвлөрсөн хадгаламжийн төвтэй Төлбөрийн үйлчилгээний гэрээ байгуулсан төлбөр гүйцэтгэх этгээдийг;
/ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор өөрчилсөн/
- 2.1.11. “Төлбөрийн эсрэг нийлүүлэлт” гэж үнэт цаасны төлбөр хийгдсэн тохиолдолд үнэт цаас шилжүүлэх баталгааг;
- 2.1.12. “Эрх бүхий байгууллага” гэж Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, хууль хяналтын байгууллагыг;
- 2.1.13. “Төлбөр гүйцэтгэх байгууллага” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасан үйл ажиллагаа эрхлэх этгээдийг;
- 2.1.14. “Төлбөр гүйцэтгэх өдөр” гэж арилжаа явагдсанаас хойш ажлын 2 хүртэлх өдрийг;
- 2.1.15. “Төлбөрийн гишүүний данс” гэж төлбөрийн гишүүн төлбөр гүйцэтгүүлэх зорилгоор Төвлөрсөн хадгаламжийн төвд нээсэн мөнгөн хөрөнгийн болон үнэт цаас шилжүүлэх дансыг;
- 2.1.16. “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК (цаашид “Клирингийн төв”) гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 43 дугаар зүйлд заасан арилжааны тооцооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;
- 2.1.17. “Харилцагч” гэж Төвлөрсөн хадгаламжийн төвд данстай Монгол улсын болон гадаадын иргэн, аж ахуйн нэгж байгууллага, Үнэт цаасны компани болон Кастодиан банк, тэдгээрийн харилцагчдыг;
- 2.1.18 “Харилцагчийн данс” гэж Үнэт цаасны компани, Кастодиан банк болон арилжааны банк, түүгээр дамжуулан Төвлөрсөн хадгаламжийн төвд харилцагчийн өөрийн нэр дээр нээсэн үнэт цаас болон түүнтэй холбоотой үүссэн төлбөр тооцоо хийх үүрэг

бүхий иргэн, хуулийн этгээдийн данс;

2.1.19 Цэвэршүүлсэн дүн” гэж Клирингийн гишүүний үнэт цаас тус бүрээр тодорхойлсон мөнгөн төлбөрийн болон үнэт цаасны шилжүүлгийн цэвэр дүнг;

/ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор өөрчилсөн/

2.1.20 “Мөнгөн төлбөрийн болон үнэт цаасны шилжүүлгийн даалгавар” гэж Клирингийн төвөөс боловсруулсан клирингийн гишүүнд хүргүүлсэн үүргийг;

2.1.21 “Төлбөр тооцооны алба” гэж Төвлөрсөн хадгаламжийн төвийн үнэт цаасны мөнгөн хөрөнгийн гүйлгээг хийж гүйцэтгэх үүрэг бүхий албыг;

/ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор өөрчлөн найруулсан/

2.1.22 “Хаалттай төлөвт байгаа данс” гэж харилцагчийн өөрийн хүсэлтээр хаалгасан, өв залгамжлал хийгдсэн, данс нэгтгэгдсэн, Хувьцаат компанийн хүсэлтээр нээгдсэн хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн данс, эрх бүхий байгууллага болон шүүхийн шийдвэрээр төвлөрсөн хадгаламж дахь тухайн харилцагчийн данснаас зарлагын гүйлгээ хийх эрхийг хязгаарласан данс;

2.1.23 “Төлбөрийн даалгавар” гэж цаасан болон цахим хэлбэртэй, мөнгөн хөрөнгийн шилжүүлэх даалгавар;

Гурав. Мөнгөн гүйлгээний хэлбэр

3.1. Төлбөр тооцооны албаар дамжуулан харилцагчийн дансанд хийгдэх мөнгөн хөрөнгийн гүйлгээ нь төвлөрсөн хадгаламж дахь мөнгөн хөрөнгийн бэлэн бус хэлбэртэй байна.

/ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор өөрчлөн найруулсан/

3.2. Төвлөрсөн хадгаламжийн төв нь үнэт цаасны компаниудтай “Мөнгөн хөрөнгийн гүйлгээний ерөнхий” гэрээ байгуулах бөгөөд түүнд үндэслэн үнэт цаасны компаниуд харилцагчтай “Мөнгөн хөрөнгийн гүйлгээний гэрээ”-г байгуулж харилцагчийг төлөөлөх эрх үүснэ.

/ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор өөрчилсөн/

3.3. Төвлөрсөн хадгаламжийн төв нь үнэт цаасны компани болон харилцагчдын хооронд байгуулсан “Мөнгөн хөрөнгийн гүйлгээний гэрээ”-г үндэслэн мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээг хийж гүйцэтгэнэ. Гэрээг цаасан эсхүл цахим хэлбэрээр байгуулж системд бүртгэнэ.

/ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор өөрчилсөн/

3.3.1. Харилцагчийн бага дүнтэй мөнгөн хөрөнгийн ~~20 сая төгрөг~~ хүртэлх зарлагын гүйлгээг Кастодиан банк, үнэт цаасны компаниас эх хувиар эсхүл цахимаар ирүүлсэн хүсэлтийн дагуу гүйцэтгэнэ.

ЛУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор өөрчилсөн/

~~3.3.2. Харилцагчийн их дүнтэй мөнгөн хөрөнгийн 20 сая төгрөгөөс дээш дүнтэй зарлагын гүйлгээг энэ журамд заасан мөнгө хүссэн өргөдлийг хүлээн авсан Кастодиан банк, Үнэт цаасны компани нь болон Төвлөрсөн хадгаламжийн төвд эх хувиар эсхүл цахимаар ирүүлснийг үндэслэн гүйцэтгэнэ.~~

ЛУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор хүчингүйд тооцсон/

Дөрөв. Мөнгөн хөрөнгийн гүйлгээнд тавигдах шаардлага

- 4.1. Мөнгөн хөрөнгийн гүйлгээний баримтын бүрдүүлбэрт тавигдах шаардлагыг Төвлөрсөн хадгаламжийн төв тогтооно.
- 4.2. Төлбөр тооцооны алба нь Үнэт цаасны компани, Кастодиан банк болон хуулийн этгээдээс баталгаажуулан эх хувиар ирүүлсэн мөнгө хүссэн өргөдлийг 2.1.7-д заасан мэдээлэлтэй тулган гүйлгээг хийнэ.
ЛУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор өөрчлөн найруулсан/
- 4.3. Мөнгөн хөрөнгийн анхан шатны баримтын үзүүлэлтүүд тодорхой, гаргацтай, бүрэн гүйцэд бөглөсөн, засваргүй, тамга /тэмдэг/-аар баталгаажиж, данс эзэмшигчийн цахим үнэмлэхийн хуулбарыг хавсаргасан байна. Данс эзэмшигчийг төлөөлөн гүйлгээ хийлгэх тохиолдолд Иргэний хуулийн 64.2-т заасан шаардлагыг хангасан итгэмжлэлийг үндэслэн төлөөлөгч анхан шатны баримтад гарын үсэг зурж баталгаажуулна. Хэрэв энэхүү үзүүлэлтүүд дутуу бол баримтыг гүйлгээний нягтлан бодогч хүлээн авахаас татгалзана. Мөнгөн хөрөнгийн эх баримтаар ирүүлэх анхан шатны баримт нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 4.3.1. Тодорхой, гаргацтай, бүрэн гүйцэд бөглөсөн, засваргүй, тамга /тэмдэг/-аар баталгаажсан байх;
 - 4.3.2. Данс эзэмшигчийн хүчинтэй иргэний үнэмлэхийн хуулбар, эсхүл иргэдэд үйлчлэх автомат машины иргэний үнэмлэхийн лавлагааны хуулбар, гадаад харилцагчдын хувьд гадаад паспортын хуулбарыг тус тус хавсаргасан байх;
 - 4.3.3. Данс эзэмшигчийг төлөөлөн гүйлгээ хийлгэх тохиолдолд Иргэний хуулийн 64.2-т заасан шаардлагыг хангасан итгэмжлэлийг үндэслэн төлөөлөгч анхан шатны баримтад гарын үсэг зурж баталгаажуулах;
- 4.4. Журмын 4.3-т заасан үзүүлэлтүүд дутуу бол баримтыг гүйлгээний нягтлан бодогч хүлээн авахаас татгалзана.
- 4.5. Мөнгөн хөрөнгийн анхан шатны баримтыг шалгаж хүлээн авсан гүйлгээний нягтлан бодогч гарын үсгээр баталгаажуулна. Нэрийн тайлал нь дардас байж болно.
- 4.6. Өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөрийг өрийн хэрэгсэл гаргагчаас цахимаар ирүүлсэн төлбөрийн хуваарийн дагуу хийж

гүйцэтгэнэ.

/ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор нэмэлт оруулсан/

Тав. Мөнгөн хөрөнгийн гүйлгээ

- 5.1. Төвлөрсөн хадгаламж дахь мөнгөн хөрөнгийн гүйлгээнд мөнгөн хөрөнгийн орлого зарлагын гүйлгээ хамаарагдана.
- 5.2. Төвлөрсөн хадгаламж дахь мөнгөн хөрөнгийн гүйлгээ нь гүйлгээний шинэ өдөр нээгдсэнээр эхэлнэ. Гүйлгээний шинэ өдөр ажлын өдөр бүрийн 09:00 цагт эхэлнэ.
- 5.3. Мөнгөн хөрөнгийн их дүнтэй гүйлгээг 09:10-16:30 цагийн хооронд гүйцэтгэнэ. Анхан шатны баримт нь тухайн ажлын өдрийн 09:00-16:15 цагт ирсэн үед Т+0 хугацаанд, 16:15 цагаас хойш ирсэн тохиолдолд Т+1 хоногт гүйлгээ хийнэ.
- 5.4. Мөнгөн хөрөнгийн бага дүнтэй гүйлгээг 09:10-17:15 цагийн хооронд гүйцэтгэнэ. Анхан шатны баримт нь тухайн ажлын өдрийн 09:00-17:15 цагт ирсэн үед Т+0 хугацаанд, 17:15 цагаас хойш ирсэн тохиолдолд Т+1 хугацаанд гүйлгээ хийнэ.
- 5.5. Мөнгөн хөрөнгийн гадаад гуйвуулгын гүйлгээг 09:00-14:30 цагийн хооронд ирүүлсэн мөнгө хүссэн өргөдлийг Т+0 хугацаанд, 14:30 цагаас хойш ирүүлсэн мөнгө хүссэн өргөдлийг Т+1 хугацаанд гүйлгээг хийж гүйцэтгэнэ.
- 5.6. Тухайн өдрийн гүйлгээний цагаас хоцорсон яаралтай зарлагын гүйлгээг “Монголбанкны их дүнтэй төлбөр тооцооны журам”-ын дагуу /16.30-17.30/ цагийн хооронд төлбөрийн даалгавраар хийх боломжтой бөгөөд энэ тохиолдолд “Монголбанкны үйлчилгээ шимтгэлийн ерөнхий нөхцөл”-ийг мөрдөнө.
- 5.7. Кастодиан банкны харилцагчийн төвлөрсөн хадгаламжийн данс дахь мөнгөн хөрөнгийг Кастодиан банк хариуцсан албанаас баталгаажуулсан жагсаалтыг үндэслэн Кастодиан банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн дансанд зарлагын гүйлгээг шилжүүлнэ.
/ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор өөрчлөн найруулсан/
- 5.8. Гүйлгээний нягтлан бодогч нь орлогын гүйлгээг банкны хуулгыг үндэслэн Төвлөрсөн хадгаламжийн дансны мэдээлэлтэй тулган шалгаж, холбогдох журмын дагуу харилцагчийн дансанд байршуулна.
- 5.9. Арилжааны банкны хуулга дээрх орлогын гүйлгээний утга нь тодорхой бус, нэр данс зөрсөн, данс нь нээгдээгүй зэрэг шалтгааны улмаас харилцагчийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршуулах боломжгүй тохиолдолд “99-100 тоот нэр данс тодорхойгүй” гэсэн дансанд тухайн гүйлгээг бүртгэнэ.
- 5.10. ~~Данс андуурч 99-20 тоот “нэр данс зөрүүтэй орлого” гэсэн дансаар орж ирсэн мөнгөн хөрөнгийн гүйлгээг ирсэн даруйд тухайн дансаар дамжуулан буцаана. Гүйлгээг буцаах боломжгүй буюу их дүнтэй гүйлгээний цаг хаагдсан нөхцөл үүссэн Нэр данс зөрүүтэй данс~~

андуурч шилжүүлсэн гүйлгээг ирсэн даруйд “нэр данс зөрүүтэй орлого”-ын дансаар дамжуулан буцаана. Тухайн гүйлгээг буцаах боломжгүй буюу их дүнтэй гүйлгээний цаг хаагдсан нөхцөл үүссэн тохиолдолд 99-20 тоот “нэр данс зөрүүтэй орлого” дансанд байршуулан дараагийн ажлын өдөр буцаах гүйлгээг хийнэ.

/ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор өөрчлөн найруулсан/

- 5.11. Нэр данс тодорхойгүй гүйлгээний дансанд орсон мөнгийг харилцагчийн дансанд байршуулахдаа мөнгө тушаагчаас ~~харилцагчаас тодруулж Хадгаламж өмчлөх эрх бүртгэл кастодианы албанаас~~ ирүүлсэн маягтыг гүйлгээний баримтад үндэслэн холбогдох хууль, журамд нийцүүлэн гүйлгээг хийнэ.

/ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор өөрчлөн найруулсан/

- 5.12. Монголбанк болон арилжааны банк дахь харилцах дансны орлого, зарлагын гүйлгээний журналыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу өдөр бүр бүртгэл хөтөлж улирлын эцэст дансны үлдэгдлийн баталгааг гаргаж, банкаар баталгаажуулна.

- 5.13. Мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээг хийхдээ гүйлгээний нягтлан бодогч нь анхан шатны баримтын мэдээллийг тухайн харилцагчийн төвлөрсөн хадгаламжийн дансны мэдээлэлтэй тулган шалгаж гүйлгээг хийнэ.

5.13.1. Гадаад харилцагчийн данснаас мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээ хийх тохиолдолд харилцагч нь ~~хөлбөгдөх хууль тогтоомж болон~~ гадаад гуйвуулгын хийх шаардлагын хүрээнд гүйлгээг шилжүүлэхэд шаардагдах шаардлагатай мэдээллүүдийг ~~энэ журмын хавсралт маягтын дагуу шаардлага хангасан анхан шатны баримтыг~~ бүрдүүлж, зуучлагч Кастодиан банк болон Үнэт цаасны компанид хүргүүлнэ.

/ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор өөрчлөн найруулсан/

5.13.2. Журмын 5.13.1 заалтын дагуу ирүүлсэн баримтыг тухайн Үнэт цаасны компани, Кастодиан банкуудын холбогдох эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулан Төвлөрсөн хадгаламжийн төвд хүргүүлнэ.

5.13.3. Журмын 4.2, 5.13.1 заалтуудын шаардлага хангаж ирүүлсэн анхан шатны баримтыг үндэслэн гүйлгээний нягтлан бодогч нь харилцагчийн мөнгөн хөрөнгийг зөвхөн тухайн харилцагчийн өөрийн нэр дээрх банкны дансанд шилжүүлнэ. Үнэт цаасны компанийн мөнгөн хөрөнгийн номинал дансаар үйлчлүүлэх хүсэлт гаргасан харилцагчид хамаарахгүй.

- 5.14. Харилцагчийн данс дах мөнгөн хөрөнгийн ~~их бөлөн бага~~ дүнтэй гүйлгээг ~~санхүүгийн төлбөр тооцооны албаны~~ гүйлгээний нягтлан бодогч хийж гүйцэтгэх ~~Мөнгөн хөрөнгийн программ болон Төлбөр тооцооны дэд системд шивэх бөгөөд~~ их дүнтэй зарлагын гүйлгээг

~~төлбөр тооцооны албаны ахлах нягтлан бодогчоор бага дүнтэй мөнгөн хөрөнгийн гүйлгээг төлбөр тооцооны албаны гүйлгээний нягтлан бодогч хянан баталгаажуулж гүйлгээг шилжүүлнэ.~~

/ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор өөрчлөн найруулсан/

5.15. Дараах тохиолдолд төвлөрсөн хадгаламжийн данснаас зарлагын гүйлгээг хийнэ.

5.15.1. Үнэт цаасны компани болон Кастодиан банкнаас баталгаажуулан ирүүлсэн цахим хэлбэрийн даалгавар болон мөнгө хүсэх өргөдлийн дагуу;

5.15.2. Зарлага хийх мэдэгдлийн дагуу;

5.15.3. Эрх бүхий байгууллага болон аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн албан тоот, тушаал шийдвэрийн дагуу;

5.15.4. ~~“Мөнгөн хөрөнгийн гүйлгээний гурвалсан гэрээ” байгуулсан харилцагчийн төвлөрсөн хадгаламжийн данснаас гарах 20 сая төгрөг хүртэлх зарлагын гүйлгээг Үнэт цаасны компаниас цахим хүсэлт ирүүлсний дагуу;~~

/ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор хүчингүйд тооцсон/

5.15.5. Мөнгөн хөрөнгийн номинал дансаар дамжуулан харилцагчдад үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийг Хорооноос авсан Үнэт цаасны компани нь Төвлөрсөн хадгаламжийн төвтэй “Төлбөрийн номинал дансны гэрээ” байгуулсан тохиолдолд харилцагч өөрөө хүсэлт гаргасан бол тухайн харилцагчийн данс дахь мөнгөн хөрөнгийг Үнэт цаасны компанийн гэрээнд тусгагдсан банкны номинал данс руу;

5.15.6. Үнэт цаасны компани болон харилцагчийн хүсэлтээр Үнэт цаасны компанийн банкны номинал данс руу харилцагчийн данснаас ногдол ашиг, ногдол хувийн мөнгийг шилжүүлэхдээ тухайн харилцагчийн Үнэт цаасны компанийн номинал дансаар үйлчлүүлэх гэрээ, номинал данс нээлгэх хүсэлт, гарын үсгийн баталгааны аль нэгийг Төвлөрсөн хадгаламжийн төвийн мэдээллийн санд заавал бүртгүүлнэ.

5.16. Дараах тохиолдолд төвлөрсөн хадгаламжийн данс хооронд мөнгөн хөрөнгө шилжүүлнэ.

5.16.1. Хорооны Улсын байцаагчийн актыг үндэслэн мөнгөн хөрөнгө шилжүүлэх;

5.16.2. Төвлөрсөн хадгаламжийн төвийн дотоод албануудаас ирүүлсэн албан бичгийн дагуу шилжүүлнэ.

5.17. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ирүүлсэн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг үндэслэн харилцагчийн данснаас мөнгөн хөрөнгийн гүйлгээг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд шилжүүлнэ.

5.18. Харилцагчийн данс нь хаалттай төлөвт буй харилцагчдад тараагдах ногдол ашиг, ногдол хувийн мөнгийг Хадгаламжийн албанаас

баталгаажуулан ирүүлсэн жагсаалтыг үндэслэн тухайн харилцагчийн дансанд байршуулна.

/ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор өөрчлөн найруулсан/

- 5.19. Албаны ахлах нягтлан бодогч мөнгөн хөрөнгийн гүйлгээний баримтын бүрдэл дутуу, сэжиг бүхий тохиолдол илэрсэн болон зээлийн барьцааны тусгаарлалтад байгааг шалгах зэрэг үндэслэлээр тухайн гүйлгээнд нэг өдрийн турш хориг тавих эрхтэй бөгөөд гүйлгээнд хориг тавьж байгаагаа холбогдох Үнэт цаасны компани болон харилцагчид тухайн өдөртөө багтаан мэдэгдэнэ.

/ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор өөрчлөн найруулсан/

- 5.20. Монголбанкны банк хоорондын их дүнтэй төлбөр тооцооны журмын дагуу Төвлөрсөн хадгаламжийн төвийн харилцах данснаас гүйлгээ хийгдсэн тохиолдолд гүйлгээ буцахгүй.
- 5.21. Төлбөр тооцооны албаны гүйлгээний нягтлан бодогч нь сэжиг бүхий гүйлгээний тухай мэдээллийг тухай бүр Дотоод хяналтын албанд мэдээлнэ.
- 5.22. Мөнгөн хөрөнгийн гүйлгээ хийх явцад систем дээр ямарваа нэгэн доголдол гарах тохиолдолд гүйлгээний нягтлан бодогч Төвлөрсөн хадгаламжийн төвийн Мэдээлэл технологийн алба, Дотоод хяналтын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.
- 5.23. Төлбөр тооцооны тасралтгүй ажиллагааг хангах үүднээс Монголбанкны их дүнтэй төлбөрийн системийн журмын 11 дүгээр бүлгийг дагаж мөрдөнө.

Зургаа. Төлбөрийн эсрэг нийлүүлэлт /DVP/-ийн мөнгөн төлбөр

- 6.1. Төлбөрийн гишүүн нь Төвлөрсөн хадгаламжийн төвтэй төлбөрийн үйлчилгээний гэрээ байгуулан ажиллана.
- 6.2. Клирингийн төвөөс ирүүлсэн мөнгөн төлбөрийн болон үнэт цаасны шилжүүлгийн даалгаварт тусгагдсан мөнгөн төлбөрийг төлбөр гүйцэтгэх өдөр, Төлбөрийн гишүүн нь энэ журам болон бусад холбогдох хууль журамд өөрөөр заагаагүй бол Төвлөрсөн хадгаламжийн төв дэх төлбөрийн гишүүний дансанд төлбөрийг бүрэн байршуулснаар төлбөр гүйцэтгэгдэнэ.
- 6.3. Төлбөрийн гишүүн нь харилцагчийн мөнгөн төлбөрийг хүлээн авах зориулалтаар зөвхөн нэг банканд данстай байна.
- 6.4. Журмын 6.3-т заасан банкныг өөрчилсөн тохиолдолд албан бичгээр Төвлөрсөн хадгаламжийн төвд мэдэгдэнэ.
- 6.5. Төлбөрийн гишүүнд зориулсан данс руу хэдэн ч банкны данс ашиглан мөнгөн төлбөрийг шилжүүлж болно.
- 6.6. Төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн үнэт цаасыг бүртгэж баталгаажуулахтай холбоотой харилцааг “Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бүртгэх үйл ажиллагааны журам”-аар зохицуулна.

Долоо. Төлбөр тооцоо хийхэд хориглох зүйлс

- 7.1. Төлбөр тооцооны албаны ажилтнуудад дараах гүйлгээ хийхийг хориглоно.
- 7.1.1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу, мэдээллийн сан дахь бүртгэлтэй мэдээллээс зөрсөн, зохих зөвшөөрөлгүйгээр гүйлгээ хийх, баримтыг хуурамчаар бүрдүүлэх, нуун дарагдуулах; холбогдох Клирингийн төв, Кастодиан банк болон Үнэт цаасны компаниар баталгаажаагүй, тамга тэмдэггүй, гарын үсэг зурагдаагүй, баримтаар зарлагын гүйлгээ хийх, тодорхой шалтгаангүйгээр орлогын гүйлгээг буцаах;
- ~~7.1.2. Факс болон и-мэйл, скайнардад ирсэн анхан шатны баримтаар гүйлгээ хийх; Энэ заалт мөнгөн хөрөнгийн гүйлгээ хийхээр гурвалсан гэрээ байгуулсан харилцагч болон гадаад харилцагчийн хувьд хамаарахгүй.~~
- /ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор хүчингүйд тооцсон/*
- 7.1.3. Мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээг Төвлөрсөн хадгаламжийн төвд данс эзэмшигч этгээдээс өөр этгээдийн харилцах дансанд шилжүүлэх; Энэ нь төлбөрийн номинал дансны гэрээ байгуулсан харилцагчид болон Кастодиан банкны харилцагчид хамаарахгүй.
- 7.1.4. Зарлагын гүйлгээг гаргахдаа итгэмжлэгдсэн төлөөлөгчийн харилцах дансанд шилжүүлэх; Ингэхдээ хүндэтгэн үзэх шалтгааныг нь тодруулж холбогдох байгууллагаас ирүүлсэн баримтуудыг үндэслэн Гүйцэтгэх захирлын зөвшөөрлөөр итгэмжлэгдсэн төлөөлөгчийн дансанд шилжүүлнэ.
- 7.2. Аж ахуйн нэгжийн данснаас хувь хүний харилцах банкны данс руу зарлагын гүйлгээ гаргах болон хувь хүний төвлөрсөн хадгаламж дахь данс руу данс хоорондын шилжүүлэг хийхийг хориглоно.

Найм. Мөнгөн гүйлгээг гүйцэтгэх

- 8.1. Төлбөр тооцооны алба нь баримт хүлээн авсан дэс дарааллыг баримтлан мөнгөн гүйлгээг цахим сүлжээний тусламжтайгаар гүйцэтгэнэ.
- /ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор өөрчлөн найруулсан/*
- 8.2. Гадаад харилцагчдын төвлөрсөн хадгаламжийн данс дахь мөнгийг гадаад дахь банкны данс руу шилжүүлэхдээ Төвлөрсөн хадгаламжийн төвийн арилжааны банк дахь харилцах дансаар дамжуулан гадаад гуйвуулгын гүйлгээг хийнэ.
- /ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор өөрчлөн найруулсан/*
- ~~8.3. Гүйлгээ хариуцсан ажилтан Үнэт цаасны компаниудын арилжааны бүс гүйлгээний файлыг VCTF форматаар, нээгдсэн дансны мэдээллийг XLS форматаар Үнэт цаасны компаниудын цахим хаягаар өдөр бүр~~

илгээнэ.

/ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор хүчингүйд тооцсон/

- 8.4. Засгийн газрын дотоодын үнэт цаасны анхдагч арилжаанд оролцогчдын арилжааны хуваарилалт хийгдэж, хэлцэл нөлөөлсний дараа төвлөрсөн хадгаламжийн дансанд үнэт цаас худалдан авахаар байршуулсан үнэт цаас худалдан авсан мөнгөн дүн болон бусад зардлыг суутган тооцож үлдсэн мөнгөн хөрөнгийг цахимаар ирүүлсэн хүсэлтийг үндэслэн шилжүүлнэ.

/ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор нэмсэн/

- 8.5. Үндсэн болон хүүгийн төлбөрийг үнэт цаас гаргагчийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршуулж, тус данснаас үнэт цаас эзэмшигчийн төвлөрсөн хадгаламжийн төвийн дансанд төлбөрийн хуваарийн дагуу шилжүүлнэ.

/ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор нэмсэн/

Ес. Өрийн хэрэгслийн төлбөр хийгдэх хугацаа

- 9.1. Төлбөр тооцооны алба нь өрийн хэрэгслийн төлбөрийг дараах хугацаанд хийж гүйцэтгэнэ

9.1.1. Засгийн газрын дотоодын үнэт цаасны болон компанийн өрийн хэрэгслийн төлбөрийг тухайн өрийн хэрэгсэл гаргагчтай байгуулсан гэрээ, холбогдох журмын дагуу;

9.1.2. Хадгалуулагч өрийн хэрэгслийн эргэн төлөгдөх үндсэн болон хүүгийн төлбөрийг тухайн төлбөр төлөгдөх өдрийн 13:00 цагаас өмнө хадгалагчийн Монголбанк дахь дансанд;

9.1.3. Өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөр 9.1.2-д заасан хугацаанд хийгдсэн тохиолдолд төлбөрийг T+0 хугацаанд;

9.1.4. Өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөр 9.1.2-д зааснаас хойш хугацаанд хийгдсэн тохиолдолд төлбөрийг T+1 хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Арав. Анхдагч арилжааны төлбөр

- 10.1 Арилжаа эрхлэх байгууллагаар хийгдэх тохиолдолд:

10.1.1. Анхдагч арилжааны төлбөрийг үнэт цаасны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллагын арилжааны баталгаажсан хэлцлээр гүйцэтгэнэ. Арилжааны баталгаажсан хэлцлийг арилжаа дууссан даруйд цахимаар еүлжээгээр бөлөн хэвлэмлээр хүлээн авч, бүртгэл—хөтөлнө Санхүүгийн зохицуулах хорооноос хоёрдогч зах зээлийн арилжаа эхлүүлэх шийдвэр гарах хүртэлх хугацаанд оролцогчдын хэлцлийн төлбөрийг тусгаарлана.

/ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор өөрчлөн найруулсан/

10.1.2. Хэлцлийг шалган, хүлээн авснаар тухайн өдрийн арилжааны гүйлгээг нэгдсэн санд нөлөөлүүлнэ. Хэлцлийг шалгах явцад

арилжааны төлбөр хүрэлцэхгүйгээс хэлцэл буцах нөхцөл үүссэн тохиолдолд энэ тухай мэдэгдлийг Хороо болон Арилжаа эрхлэх байгууллагад албан ёсоор ажлын нэг өдөрт багтаан мэдэгдэнэ.

10.1.3. Анхдагч арилжааны шимтгэлийн мөнгийг эрх бүхий байгууллагын тогтоол, холбогдох журам, мэргэжлийн оролцогч байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн хэлцэл хийгдсэн тал тус бүрээс суутган, Т+0 хугацаанд шилжүүлнэ.

10.1.4. Анхдагч зах зээл дээр арилжигдсан арилжааны үнийн дүнгээс авах Үнэт цаасны компаниудын шимтгэлийг тухайн Үнэт цаасны компаниудын өөрийн данс /house account/-д шилжүүлнэ.

10.2 Андеррайтераар хийгдэх тохиолдолд:

10.2.1. Анхдагч зах зээлд нийтэд санал болгон анх удаа болон нэмж гаргах үнэт цаасны арилжааны үйл ажиллагааг андеррайтер бие даан зохион байгуулсан бол андеррайтераас ирүүлсэн баталгаажсан захиалгын бүртгэлийг тухайн арилжааны үйл ажиллагаа дууссан даруйд төвлөрсөн хадгаламжийн байгууллага цаасаар болон цахимаар хүлээн авч, түүнийг үндэслэн төлбөрийг гүйцэтгэнэ.

10.2.2. Андеррайтер бие даан арилжааг зохион байгуулсан үед татан төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийг андеррайтерын банк дах өөрийн номинал дансанд хүлээн авч болно.

10.2.3. Арилжааны захиалга дууссан өдрөөр амжилттай биелсэн үнэт цаасанд ногдох мөнгөн хөрөнгийн нийт дүнгээр үнэт цаасны компанийн төвлөрсөн хадгаламж дах мөнгөн хөрөнгийн номинал дансанд байршуулж барилт хийнэ.

10.2.4. Санхүүгийн зохицуулах хорооноос ирүүлсэн зөвшөөрлийг үндэслэн арилжааны баталгаажсан захиалгын дагуу төлбөрийн эсрэг нийлүүлэлт хийгдэнэ.

10.2.5. Төлбөрийн эсрэг нийлүүлэлт амжилттай хийгдсэн тохиолдолд үнэт цаас гаргагчийн татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг түүний холбогдох банкны дансанд ажлын 2 өдөрт багтаан шилжүүлнэ.

Арван нэг. Шимтгэл, хураамж

11.1. Төлбөрийн үйлчилгээний шимтгэл, хураамжийг журмын Хавсралт 1-т заасны дагуу тооцно.

/ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор өөрчилсөн/

11.2. Арилжаа эрхлэх байгууллагаар хийгдсэн үнэт цаасны арилжааны хэлцэл нь Хорооны тогтоол болон шүүхийн шийдвэрээр буцах тохиолдолд өмнө тооцогдсон шимтгэлийг үнэт цаасны зах зээлд оролцогч байгууллагаас суутгах үүргийг Төвлөрсөн хадгаламжийн төв хүлээхгүй.

11.3. Журмын 11.1-д заасан банк хоорондын төлбөр—төөцөөны үйлчилгээний шимтгэлийг гүйлгээний шимтгэлээс “Монгол банкны хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д заасны дагуу харилцагчийн

~~данснаас гүйлгээ тутамд тооцож авна Монголбанканд шилжүүлнэ.~~

~~/ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор өөрчлөн найруулсан/~~

- 11.4. Харилцагчийн данснаас хийгдсэн гадаад гуйвуулгын гүйлгээний дамжуулагч банкны шимтгэлийг Төвлөрсөн хадгаламжийн төв хариуцахгүй бөгөөд тухайн арилжааны банкны шимтгэлийн хувь хэмжээгээр харилцагч өөрөө хариуцна.

- ~~11.5. Банк хоорондын гүйлгээний шимтгэлийг харилцагчийн болон төлбөрийн гишүүний данснаас гүйлгээ тутамд 500 төгрөгөөр тооцно.
/ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор хүчингүйд тооцсон/~~

Арван хоёр. Албаны тайлан мэдээ, маягт

- 12.1. Төвлөрсөн хадгаламжийн төвийн мөнгөн хөрөнгийн тайланг өдөр бүрээр гаргах бөгөөд үйл ажиллагааны талаарх тайлан мэдээг дараах байдлаар гаргана. Үүнд:

12.1.1 Төвлөрсөн хадгаламжийн данснаас мөнгө хүссэн өргөдөл /Маягт-1/

12.1.2 Төвлөрсөн хадгаламжийн данснаас зарлага хийх мэдэгдэл /Маягт-2/

12.1.3 Төвлөрсөн хадгаламж дахь ногдол ашиг, ногдол хувь, өрийн хэрэгслийн мөнгөн хөрөнгийг арилжааны төлбөрт шилжүүлэх хүсэлт /Маягт-3/

12.1.4 Мөнгөн хөрөнгийн орлогын нэгдсэн тайлан /Маягт-4/

12.1.5 Мөнгөн хөрөнгийн зарлагын нэгдсэн тайлан /Маягт-5/

~~12.1.6 Мөнгөн хөрөнгийн гүйлгээний хураангуй мэдээ /Маягт-6/~~

~~/ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор хүчингүйд тооцсон/~~

12.1.7 Мөнгөн хөрөнгийн баланс /Маягт-7/

~~12.1.8 ҮЦТХТ-ийн харилцах дансны орлого, зарлагын гүйлгээний баланс (Амжилттай, Амжилтгүй) /Маягт-8/~~

~~/ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор хүчингүйд тооцсон/~~

~~12.1.9 ҮЦТХТ-ийн харилцах дансны орлого, зарлагын гүйлгээний баланс (Бага дүнтэй гүйлгээ өрөөгүй) /Маягт-9/~~

~~/ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор хүчингүйд тооцсон/~~

12.1.10 Харилцах банкнуудын дансны үлдэгдэл /Маягт-10/

~~12.1.11 Харилцах банкнуудын дансны үлдэгдэл (Бага дүнтэй гүйлгээ өрөөгүй) /Маягт-11/~~

~~/ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор хүчингүйд тооцсон/~~

12.1.12 Монгол банкны тохируулгын тайлан /Маягт-12/

12.1.13 Мөнгөн хөрөнгийн шилжүүлгийн нэгдсэн тайлан /Маягт-13/

~~12.1.14 Харилцах банк, урт болон богино хугацаат хөрөнгө оруулалтын дансны нийт үлдэгдэл /Маягт-14/~~

ЛУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор хүчингүйд тооцсон/

~~12.1.15 Урт болон богино хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэл
/Маягт-15/~~

ЛУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор хүчингүйд тооцсон/

12.1.16 Цахим холболтоор ирсэн гүйлгээний жагсаалт

- 12.2. Төлбөр тооцооны албанаас гарах мэдээ, тайлан судалгаа нь санхүүгийн албаны ахлах нягтлан бодогчоор хянагдаж газрын захиралд танилцуулсан байна.

ЛУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор өөрчлөн найруулсан/

Арван гурав. Баримтын хадгалалт, нууцлалт

- 13.1. Төлбөр тооцооны албанаас гарах мэдээ тайлангийн хадгалалт, нууцлалыг ажилтан бүр хариуцан ажиллах бөгөөд Төвлөрсөн хадгаламжийн төвийн “Нууцын тухай журам”, “Мэдээллийн аюулгүй байдлын журам”-аар зохицуулагдана.
- 13.2. Мөнгөн хөрөнгийн гүйлгээний баримтыг хүлээн авч хариуцсан ажилтан нь тухай бүр хавтаслаж, дугаарлан өөрийн цоож, лацтай сейф, шүүгээнд хадгалах бөгөөд Төвлөрсөн хадгаламжийн төвийн “Нууцын тухай журам”-д зааснаар архивлах хэмжээнд хүрмэгц архивд шилжүүлнэ.
- 13.3. Ажилтнууд “Нууцын тухай журам”-д заасан нууцын зэрэглэлд хамаарах баримт бичгийг архиваас авч ашиглахдаа нууцын эрхлэгчид мэдэгдэнэ.

Арван дөрөв. Хариуцлага

- 14.1. Журмын 4,5,6 дугаар бүлгийг зөрчсөн холбогдох ажилтан хариуцлагыг бүрэн хүлээх ба компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар Төвлөрсөн хадгаламжийн төвийн Дотоод журамд заасан сахилгын шийтгэл ногдуулна.
- 14.2. Мөнгөн хөрөнгийн гүйлгээнд банкны буруутай үйлдлээс үүдэн гарах аливаа хохирлыг Төвлөрсөн хадгаламжийн төв хариуцахгүй.
- 14.3. Клирингийн төв, Кастодиан банк, Номинал данс эзэмшигч, Арилжааны банк, зуучлагч Үнэт цаасны компани нь мөнгөн хөрөнгийн гүйлгээний гэрээ болон анхан шатны баримтын бүрдэл, мэдээллийн үнэн зөв байдлыг бүрэн хариуцна.
- 14.4. Харилцагчийн данснаас хийгдэх зарлагын гүйлгээтэй холбоотой анхан шатны баримтын үнэн зөвийг тухайн гүйлгээг хийлгүүлэхийг зөвшөөрч баталгаажуулсан зуучлагч Үнэт цаасны компани бүрэн хариуцна.
- 14.5. Энэхүү журмыг зөрчсөн үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй бол Санхүүгийн зохицуулах хороо болон холбогдох хууль хяналтын байгууллагад хандан шийдвэрлүүлнэ.

Арван тав. Бусад

- 15.1 Энэхүү журамд Төвлөрсөн хадгаламжийн төвийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 15.2 Мөнгөн хөрөнгийн гүйлгээтэй холбоотой харилцаанд Төвлөрсөн хадгаламжийн төвийн дотоод буруутай үйл ажиллагаанаас үүдэн аливаа эрсдэл бий болсон тохиолдолд учирсан хохирлыг Төвлөрсөн хадгаламжийн төвийн “Эрсдэлийн санг үүсгэн байгуулах, захиран зарцуулах журамд”-д заасны дагуу барагдуулна.
- 15.3 Энэ журмаар зохицуулагдаагүй аливаа харилцааг бусад холбогдох хууль журмаар зохицуулна.

“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

---ООО---

Анхдагч арилжааны төлбөрийн үйлчилгээний хөлс

Энэ журмын 10.1-д заасан үнэт цаасны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллагын анхдагч зах зээлийн арилжаагаар хийсэн худалдах ба худалдан авах хэлцэл тус бүрийн үнийн дүнгээс, 10.2-д заасан андеррейтараас ирүүлсэн баталгаажсан худалдах ба худалдан авах захиалга тус бүрийн үнийн дүнгээс доорх хувиар шимтгэл тооцно.

Үйлчилгээний төрөл	Хувь хэмжээ
Хувьцаа, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	Худалдсан ба худалдан авсан тал тус бүрээс 0.12 хувь
Компанийн өрийн хэрэгслийн арилжаа	Худалдсан ба худалдан авсан тал тус бүрээс 0.0075 хувь
Засгийн газрын дотоодын үнэт цаасны арилжаа	Худалдсан талаас 0.00175 хувь, Худалдан авсан талаас 0.00375 хувь
Аймаг, нийслэлийн үнэт цаасны арилжаа	Худалдсан талаас 0.00175 хувь, Худалдан авсан талаас 0.00375 хувь
Банк хоорондын гүйлгээний шимтгэл	Гүйлгээ тутмаас 500 төгрөг

/ Энэ хэсэгт ТУЗ-ын 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор нэмсэн /

/ Энэ хэсэгт ТУЗ-ын 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тогтоолоор хассан /

ТУЗ-ын 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 14 тоот тогтоолоор хассан тооцсон

/ Энэ хэсэгт ТУЗ-ын 2023 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан/